



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 04 өдөр

Дугаар A/535

Улаанбаатар хот

Г

Журам батлах тухай

Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.13 дахь заалт, Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын 2.1 дэх зорилтын 2.1.9, 2.1.10, 9.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааны журам"-ыг баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т, журмын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Н.Нарангэрэл)-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2023 оны 4 дугаар сарын 04 -ны өдрийн  
15:35 дугаар тушаалын хавсралт

## НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "Насан туршийн суралцахуйн төв" нь Боловсролын ерөнхий хуулийн 17.6-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Боловсролын ерөнхий газар)-ын харьяанд ажиллах бөгөөд аймаг, нийслэл, дүүргийн "Насан туршийн суралцахуйн төв" (цаашид "төв" гэх) хамаарна.

1.2. Аймаг, нийслэл, дүүргийн төвийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох харилцааг Боловсролын ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү журмаар зохицуулна.

1.3. Төв нь үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хуульд заасан зарчмыг баримтлан холбогдох хууль тогтоомж, эрх бүхий этгээдийн баталсан шийдвэр, зөвлөмж болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.4. Төв нь холбогдох хууль тогтоомж болон энэхүү журамд заасан үйл ажиллагааг хүний эрх, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, нээлттэй, уян хатан, салбар дундын болон олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг ханган, чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилж зохион байгуулна.

Хоёр. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

2. Төв нь Боловсролын ерөнхий хууль болон бусад холбогдох хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн түвшинд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.1. Бүх насны иргэд насан туршдаа суралцах эрх тэгш боломж бүхий нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр:

2.1.1. насан туршийн суралцахуйн талаар батлагдсан холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах;

2.1.2. иргэдийн насан туршийн суралцахуйг дэмжих, иргэдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллах, түншлэлийг бэхжүүлэх;

2.1.3. орон нутгийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн насан туршийн суралцахуйн мэдээллийн сан бүрдүүлж, энэ сангийн мэдээллийн хүртээмжийг хангах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх;

2.1.4. иргэд албан бус болон амьдралын орчинд суралцах нээлттэй сургалтын санг бүрдүүлж, түгээн дэлгэрүүлэх, иргэдэд суралцах боломжийг бий болгох;

2.1.5. насан туршийн суралцахуйн үндэсний нэгдсэн системд шаардлагатай статистик мэдээллийг бүрдүүлэх, үйл ажиллагаандаа тогтмол ашиглах;

2.1.6. Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогод тусгасан хүний эрхийн мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, цахим ур чадвар, эрүүл мэнд, эрүүл аж төрөх, тогтвортой хөгжлийн ур чадвар, хөдөлмөр эрхлэх ур

чадварыг хөгжүүлэхтэй холбоотой бодлогын шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг орон нутгийн онцлогийг харгалзан тодорхойлох, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн орон нутгийн төсөвт сууѓахад аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн Засаг дарга наарт холбогдох хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.1.7.насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг салбарын хэмжээнд орон нутгийн бодлого, арга хэмжээ, төлөвлөгөөнд тусгах, зохицуулалт хийх, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, гүйцэтгэлийг эрх бүхий байгууллагад тайлагнах;

2.1.8.орон нутгийн иргэдийн бичиг үсэг, болон бусад суурь ур чадвар, боловсролд хамрагдалтын тандалт судалгаа 3 жил тутам хийж, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох арга хэмжээг орон нутгийн байгууллага болон хуульд заасан бусад боловсролын харилцаанд оролцогч төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах;

2.1.9.орон нутгийн иргэдийн насан туршийн суралцахуйг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг Боловсролын ерөнхий газар, аймаг, дүүргийн Засаг даргатай хамтран гүйцэтгэлийн гэрээнд суурilan хийх, зарцуулах, үр дүнг гэрээ байгуулсан талуудад тайлагнах.

2.2. Иргэдийн боловсрол эзэмших, бие даан суралцахад дэмжлэг үзүүлэх, удирдан зохион байгуулах чиглэлээр:

2.2.1.ерөнхий боловсролын сургууль завсардсан сургуулийн насын хүүхдэд боловсрол нөхөн эзэмшүүлэх үйл ажиллагааг ерөнхий боловсролын сургуультай, насанд хүрэгчдэд ерөнхий боловсролыг нөхөн эзэмшүүлэх ажлыг орон нутгийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж, орон нутгийн хүүхэд, залуучуудын ерөнхий боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх, эрх тэгш боломжийг бий болгож ажиллах;

2.2.2.иргэдэд бичиг үсгийн боловсрол эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж, удирдан чиглүүлэх;

2.2.3.хууль тогтоомжид заасны дагуу танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг эрх бүхий байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн байгууллагатай байгуулсан түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлж болно;

2.2.4.аймаг, нийслэлийн дүүрэг болон гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй насан туршийн суралцахуйн төвтэй хамтран ажиллах;

2.2.5.насан туршийн суралцахуйн бодлого, арга хэмжээнд нийцүүлэн орон нутгийн иргэдийн сурч хөгжих хэрэгцээ, хөдөлмөр эрхлэх ур чадварын судалгаа хийх, үр дүнд үндэслэн боловсрол, сургалтын болон бусад үйлчилгээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

2.2.6.орон нутагт насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг зохион байгуулахдаа эдийн засгийн салбар хоорондын, салбарын байгууллага хоорондын, орон нутаг, дүүргүүдийн хамтын ажиллагааг хангах, хамтарсан санхүүжилт, төлөвлөгөө хэрэгжүүлэх;

2.2.7.иргэдийн албан, албан бус сургалт, амьдралын орчноос сурч, эзэмшсэн мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, үнэлэх, баталгаажуулах

ажлыг хамтран зохион байгуулж, мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллага, иргэдийг мэдээллээр хангах;

2.2.8.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын орон нутагт дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зохион байгуулалтаар хангах.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1. Төв нь холбогдох хууль тогтоомж болон энэхүү журамд заасан чиг үүрэг, мэргэжил, арга зүйн удирдлагыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтэцтэй байна.

3.2. Төвд Боловсролын ерөнхий хуулийн 26.1.2-т заасны дагуу багш, удирдах захирал, менежер, албан бус боловсролын багш, бусад ажилтан ажиллах бөгөөд үйл ажиллагааны хүрээ, онцлогоос хамаарч сургалтын менежер, бусад ажилтантай байж болно.

3.3. Төвийн удирдах ажилтан буюу захирал нь бусад хууль тогтоомжид заасны дагуу байгууллагын дарга, төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллана.

3.4. Төвийн сургалтын менежер нь бакалавр, түүнтэй адилтгах болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, үүнээс 5-аас доoshгүй жил боловсролын сургалтын байгууллагад ажилласан туршлагатай байна.

3.4.1.төвийн менежер нь иргэдийн насан туршийн суралцахуйг дэмжих, иргэдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, холбогдох талуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг дэмжих замаар боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үндсэн үүрэгтэй.

3.5. Албан бус боловсролын багш нь дээд боловсролтой, багшлах эрхийн гэрчилгээтэй, суралцагчийн онцлогт нийцсэн сургалт зохион байгуулж, хууль тогтоомжид заасан үүргийг хэрэгжүүлнэ.

3.6. Төвийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, үр дүн, хүний нөөц, төсөв, санхүүгийн болон хуулиар хориглосноос бусад мэдээллийг байгууллагын цахим хуудас/мэдээллийн самбарт байршуулах замаар байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангана.

3.7. Төвийн үйл ажиллагааг олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан шударга, хүртээмжтэй, ил тод, нээлттэй, тэгш байдлыг ханган хэрэгжүүлнэ.